

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: Энэ долоо хоногт АНУ-ын зах зээлийн индексүүд уналттай хаагдлаа. АНУ-ын газрын тосны нөөц нэмэгдэж, хөгжиж буй орнуудын газрын тосны эрэлт багассанаар газрын тосны үнэ болон S&P 500 индексийн сагсанд багтдаг эрчим хүчний салбарын компаниудын хувьцааны ханш унажээ. Аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаагаа явуулж буй компаниудын хувьцааны ханш өссөн бол мэдээлэл технологийн салбарын компаниудын хувьцааны ханш сул байв.

Лхагва гарагт “Facebook” болон “Twitter” компаниудын эрх бүхий албан тушаалтнууд АНУ-ын Сенатын тагнуулын хорооны сонголд оролцон, 2016 оны Ерөнхийлөгчийн сонгуульд ОХУ-ын талаас үзүүлэх нөлөөнд хангалттай хурдан зохих арга хэмжээ авч чадаагүй, бэлтгэлгүй байсан зэргээр тодорхой хэмжээнд буруугаа хүлээн зөвшөөрсөн тайлбар өгчээ. Ингэснээр, тус хоёр компанийн хувьцааны ханш унажээ.

АНУ, Канад улсын хоорондын НАФТА хэлэлцээрт тодорхой хэмжээний ахиц гарлаа.

АНУ нь 200 тэрбум ам.долларын тарифаас гадна БНХАУ-ын 267 тэрбум ам.долларын бараа бүтээгдэхүүнд ахин тариф тогтоох талаар мэдээлсэн. Түүнчлэн, АНУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газар Япон улстай баримталж буй худалдааны бодлогоо шинэчлэх талаар мэдэгдлээ.

АНУ-ын Хөдөлмөрийн яамны мэдээлснээр 8-р сард ажилгүйдлийн түвшин хамгийн доод хэмжээнд хүрч, дундаж цагийн цалингийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.9%-аар өсчээ.

Европ: АНУ-ын худалдааны бодлогын тодорхойгүй байдал болон Европын компаниудын хувьцааны хөөсрөл тус бүс нутгийн индекст сөргөөр нөлөөлжээ.

Италийн Засгийн газар Европын холбооноос тус улсын төсвийн зардалд тавьсан хоригийг биелүүлнэ хэмээн мэдээлснээр Итали улсын компаниудын хувьцааны ханш өслөө.

Германы худалдааны тэнцлийн ашиг буурч, сүүлийн 4 жилд үзэгдээгүй доод түвшинд хүрчээ. Тус улсын аж үйлдвэрийн гарц 1.1%-аар буурч, эдийн засгийн өсөлт нь удааширч эхэллээ.

Япон: Япон улсын Хоккайдо арал дээр болсон хүчтэй хуй салхи болон газар хөдлөлтөөс болж тус улсын зах зээлийн индекс сүүлийн хоёр сарын хугацаанд үзэгдээгүй их хэмжээгээр буурлаа. Юанийн ханш ам.долларын эсрэг бага зэрэг суларч 111.0 болжээ.

БНХАУ: АНУ нь БНХАУ-ын импортын бараа бүтээгдэхүүнд татвар ногдуулах талаар мэдээлж, Хятад улсын зах зээлийн индексүүд уналттай хаагдлаа.

Эх сурвалж: Reuters, Troweprice

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	19,915.05	0.37% ▲
Dow Jones	АНУ	25,916.54	-0.19% ▼
S&P 500	АНУ	2,871.68	-1.03% ▼
Nasdaq	АНУ	7,902.54	-2.55% ▼
S&P/TSX	Канад	16,090.27	-1.06% ▼
FTSE 100	Их Британи	7,277.70	-2.08% ▼
S&P/ASX 200	Австрали	6,143.80	-2.91% ▼
Nikkei 225	Япон	22,307.06	-2.44% ▼
Hang Seng	Хонг Конг	26,973.47	-3.28% ▼

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.7%	108.53
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.6%	95.74
Mongol 2022 (Чингис)	USD	5.1%	95.27
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.8%	112.48
DBM' 23 (Самурай)	JPY	1.5%	104.27
TDBM' 2020	USD	9.3%	105.48

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.131	0.02 ▲
Libor 3M	2.331	0.01 ▲
Libor 6M	2.542	0.01 ▲
Libor 1YR	2.846	0.01 ▲
US 6M Bond	2.296	0.04 ▲
US 2YR Bond	2.697	0.07 ▲
US 3YR Bond	2.764	0.07 ▲
US 5YR Bond	2.813	0.07 ▲
US 10YR Bond	2.931	0.07 ▲

Валютын ханш /төг/

Валют	2018.09.07	Өөрчлөлт
USD	2,479.46	0.26% ▲
CNY	362.64	0.18% ▲
EUR	2,887.58	-0.06% ▼
RUB	35.87	-1.35% ▼
KRW	2.21	-0.45% ▼
JPY	22.39	0.31% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,196.92	-0.10% ▼
Мөнгө /spot/	USD/t oz.	14.17	-2.21% ▼
Зэс	USD/lb.	262.25	-1.67% ▼
Нүүрс	USD/MT	113.00	2.59% ▲
WTI газрын тос	USD/bbl.	67.75	-2.99% ▼
Brent газрын тос	USD/bbl.	76.83	-1.02% ▼
Байгалийн хий	USD/MMBtu	2.78	-4.14% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2018. VII	7.70%
Бодлогын хүү	2018. VII	10.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018. VII	9.80%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018. VII	12.30%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018. VII	5.20%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018. VII	17.60%
Зээлийн дундаж хүү /валют/	2018. VII	10.70%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 45 компанийн 767.1 сая төгрөгийн 1,602,675 ширхэг хувьцаа арилжигдав.


“Таван толгой” /TTL/ компанийн хувьцаа 17.99%-аар буюу хамгийн ихээр өсч 8,100 төгрөгт хүрч хаагдсан бол “Монгол шилтгээн” /MSH/ компанийн хувьцаа 25.00%-аар буурч 300 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны зах зээл дээр нийт 1,520 ширхэг үнэт цаас 152.0 сая төгрөгөөр арилжаалагджээ.


9-р сарын 7-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,314.9 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,915.05 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.37%-аар өссөн байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2018 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	919.1
Зах зээлийн үнэлгээ	2,314,925.3

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	19,915.05	0.37% ▲
MSE I индекс	9,580.44	3.45% ▲
MSE II индекс	9,107.07	-1.28% ▼

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Монголын цахилгаан холбоо	517,656	280,541,526
ЛэндМН ББСБ	407,328	27,243,658
АПУ	179,427	99,672,252
Монгол базальт	169,933	58,118,685
Эрдэнэ ресурс	78,612	50,502,965
девелопмент корпорейшн		

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Таван толгой	8,100.00	17.99% ▲
Атар-Өргөө	69,900.00	15.54% ▲
Дорнод импекс	138.86	15.00% ▲
Алтайн зам	11,320.00	14.98% ▲
Жинст-Увс	17,300.00	8.64% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Монгол шилтгээн	300.00	-25.00% ▼
Тав	13,100.00	-14.94% ▼
Увс чацаргана	600.00	-11.11% ▼
Шарын гол	2,000.00	-11.11% ▼
Дархан нэхий	17,300.00	-10.22% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Мирэ Эссет Секьюритис Монгол	660,658,524
Бумбат-Алтай	351,466,035
Би Ди Сек	249,734,897
Голомт Капитал	244,045,797
Ти Ди Би Капитал	123,427,382

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	542.50	577,318
Таван толгой	8,100.00	426,588
Говь	31,340.00	244,487
МИК	10,980.00	227,388
Сүү	208.00	71,552

ЗГҮЦ БОЛОН КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

ЗГҮЦ-ны анхдагч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-20/06/20-A0260-15.14	760	76,000,000	100,000	100,000	156	15.140%
2	ZGEB-BD-20/06/20-A0260-15.14	760	76,030,400	100,040	100,040	156	15.140%

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Симбол	Компанийн нэр	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Нийт ногдол ашиг /сая төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.08.31	2018.09.10	2018.10.01-2018.11.30
2	ERS	Монгол алт	150.00	39.88	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор
3	TEE	Тээвэр дархан	500.00	81.67	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор
4	TTL	Таван Толгой	2,410.00	126,923.13	2018.04.16	2018.04.03	2018.06.12-нд олгов
5	EER	Ариг гал	21.33	74.21	2018.04.25	2018.04.02	2018.09.01-с
6	BDL	Могойн гол	100.00	82.96	2018.04.26	2018.01.18	2018.06.26-нд олгов
7	DSS	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ	56.60	7.66	2018.03.07	2018.03.27	2018.07.02-с
8	TAL	Талын гал	50.00	34.71	2018.03.05	2018.04.26	2018.12.31-ний дотор
9	BRC	Барилга корпораци	700.00	28.46	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй
10	AND	Анд-Энерги	1.27	99.15	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй
11	SUL	Жуулчин дютти фрий	10,000.00	653.62	2018.02.23	2018.04.11	2018.05.01-с
12	GTL	Гутал	1,270.00	83.01	2018.02.19	2018.03.18	2018.07.06-с
13	BNG	Баянгол зочид буудал	355.00	150.19	2018.02.19	2018.04.06	2018.09.01-с
14	APU	АПУ	10.00	10,641.82	2018.02.19	2018.03.29	2018.05.17-нд олгов
15	BTG	Баянтээг	100.00	25.26	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор
16	MIE	Материалимпекс	10.00	13.68	2018.02.19	2018.03.26	2018.04.17-нд олгов
17	HRD	Хүрд	497.00	67.23	2018.02.15	2018.02.23	2018.06.30-ны дотор
18	SUU	Сүү	3.00	1,032.00	2018.02.14	2018.04.05	2018.06.04-нд олгов
19	MNP	Монгол шуудан	3.68	366.48	2018.02.13	2018.04.13	2018.06.05-нд олгов
20	MMX	Махимпекс	100.00	380.07	2018.02.13	2018.04.05	2018.10.01-с
21	TCK	Талх чихэр	170.00	174.03	2018.02.12	2018.04.06	2018.07.01-с
22	GHC	Ган Хийц	100.00	24.25	2018.02.09	Тодорхойгүй	Тодорхойгүй
23	ADL	Адуун чулуун	130.00	409.67	2018.02.07	2018.03.01	2018.06.26-нд олгов
24	TAH	Тахь-ко	108.00	128.52	2018.02.05	2018.03.30	2018.05.01-ний дотор
25	UBH	Улаанбаатар хивс	100.00	40.48	2018.02.05	2018.02.26	2018.05.01-с
26	GOV	Говь	220.00	1,716.25	2018.02.02	2018.03.27	2018.04.24-с олгов
27	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.01.24	2018.02.15	2018.04.12-нд олгов

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Үнэт цаасны бүртгэлийн ангилал шинэчлэгдлээ

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалтын дагуу бүртгэлтэй хувьцаат компаниудын 2017, 2018 оны үзүүлэлтийг харгалзан үнэт цаасны ангиллыг Гүйцэтгэх захирлын 2018 оны 9-р сарын 04-ний А/100 тоот тушаалаар шинэчлэн тогтоолоо.

Үүний дагуу “Баянгол зочид буудал” ХК-ийг ангилал ахиулж I ангилалд, “Жинст-Увс” ХК, “Хөвсгөл Алтандуулга” ХК болон “ЛендМН ББСБ” ХК-ийг ангилал ахиулан II ангилалд, “Түшиг уул” ХК-ийг ангилал бууруулан III ангилалд тус тус бүртгэлээ.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

“Мандал даатгал” ХК-ийн үнэт цаасны анхдагч зах зээлийн захиалгын нээлт, цан цохих ёслол боллоо

Монголын хөрөнгийн биржийн I ангилалд шинээр бүртгэгдсэн “Мандал даатгал” ХК-ийн үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг нээж цан цохих ёслолын үйл ажиллагаа өнөөдөр боллоо. Энэхүү арга хэмжээнд Санхүүгийн Зохицуулах Хорооны дэд дарга Д.Баярсайхан, Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирал Х.Алтай, “Мандал даатгал” ХК-ийн ТУЗ-ийн дарга Ө.Ганзориг, “Мандал даатгал” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Жавхлан болон “Голомт Капитал ҮЦК” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Э.Амарбаясгалан нар оролцож, Монголын хөрөнгийн биржийн 5,799 дахь арилжааг эхлүүлэх хүндэтгэлийн цанг цохилоо.

Тус компани нь нийт хувьцааныхаа 25 хувь буюу 1,560,754 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 4800 төгрөгөөр олон нийтэд санал болгон худалдаалж, нийт 7.49 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэхээр үнэт цаасны худалдан авах захиалгыг 9-р сарын 4-ны өдрөөс эхлэн Монголын хөрөнгийн биржийн бүх гишүүн үнэт цаасны компаниудаар дамжуулан 2018 оны 9-р сарын 18-ны өдрийн 15 цаг хүртэл хүлээн авна.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



“Гермес центр” ХК ногдол ашиг хуваарилахаар боллоо

“Гермес центр” ХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 8-р сарын 31-ний өдрийн №1 тоот тогтоолоор 2018 оны эхний хагас жилийн 461.4 сая төгрөгийн цэвэр ашгаас 85.1% буюу нийт 392.7 сая төгрөгийг ногдол ашиг болгон хувьцаа эзэмшигчдэд хуваарилахаар шийдвэрлэсэн байна. Ингэснээр тус компанийн нэгж хувьцааны ногдол ашиг 5 төгрөгтэй тэнцлээ.

Энэхүү ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2018 оны 9-р сарын 10-ны өдрөөр гаргаж “ҮЦТХТ” ТӨХК дахь хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахаар болсон байна.

“Гермес центр” ХК жилд хоёр удаа ногдол ашиг хуваарилдаг билээ.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

“Алтайн зам” ХК-ийн үнэт цаасны арилжааг нээлээ

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн 3-р ангилалд бүртгэлтэй “Алтайн зам” ХК-ийн үнэт цаас цөөн тоогоор, үнийн огцом өсөлттэйгээр удаа дараа арилжаалагдсантай холбогдуулан тус үнэт цаасны арилжааг 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрөөс зогсоож, зөрчлийн хэрэг үүсгэн шалгасан нь хянан шийдвэрлэгдсэн тул СЗХ-ны Улсыг байцаагчийн 2018 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 49 тоот албан шаардлагын дагуу үнэт цаасны арилжааг 2018 оны 9 дүгээр сарын 03-ны өдрөөс нээлээ.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



“Зоос гоёл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

“Зоос Гоёл” ХК-ийн 2017 оны 4-р сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар компанийн хэлбэрийг өөрчлөн хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох тухай шийдвэр гаргасныг үндэслэн “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК болон Санхүүгийн зохицуулах хороо “Зоос Гоёл” ХК-ийг үнэт цаасны бүртгэлээс хассан.

Үүнтэй холбогдуулан энэхүү асуудлын эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид Компанийн тухай хуулийн 53, 54 дүгээр зүйлд заасны дагуу өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн авахыг компаниас шаардах эрх үүссэнийг үүгээр мэдэгдэж байна.

Хувьцаагаа эргүүлэн худалдан авах шаардах эрх үүссэн өдөр: 2018.08.29

Хувьцааг эргүүлэн худалдан авах үнэ: 289,440 төгрөг

Жич: СЗХ-ны 2015 оны 366 тоот тогтоолын дагуу нэгтгэгдсэн 1 бүхэл хувьцаа (1 бүхэл = 366 тоот тогтоолоос өмнөх 288 ширхэг хувьцаа)

Хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтийг хүлээн авах эцсийн өдөр: 2018.10.15.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

“Таван толгой” ХК-аас ирүүлсэн мэдэгдэл

Монголын хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэлтэй “Таван толгой” ХК-ийн түр хугацаанд зогсоод байсан нүүрс борлуулалтын үйл ажиллагаа 2018 оны 08 сарын 16-ны өдрөөс эхлэн хэвийн явагдаж эхэллээ. Ингэснээр Тавантолгой-Цагаанхад, Цагаанхад – Ганцмод боомт чиглэлийн дагуу коксжих, сул коксжих болон коксжих чанаргүй ангиллын нүүрсийг борлуулж байна.

Харин Тавантолгой-Ганц модны боомт чиглэлд үүсээд байгаа 50-70 км урт цуваа бүхий тээврийн замын ачаалал буурч, замын ачаалал хэвийн болсон тохиолдолд Тавантолгой-Ганцмод /уртын урт/ чиглэлд нүүрс тээвэрлэн борлуулж, экспортын орлогоо нэмэгдүүлэх боломжтой болох юм.

Борлуулалт зогссон хугацаанд компанийн дотоод ажлуудаас гадна хөрс хуулалт болон бусад өдөр тутмын ажлуудыг хийж гүйцэтгэн ажилласан нь борлуулалтыг нэмэгдүүлэх боломжийг бий болгож байна гэж компанийн зүгээс мэдээллээ.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

ШИНЭ IPO

Үзүүлэлт	“Мандал даатгал” ХК	“Ард даатгал” ХК
Хувьцаа		
Үнэт цаас гаргагч:	“Мандал даатгал” ХК	“Ард даатгал” ХК
Үнэт цаасны символ:	MNDL	AIC
Хувьцааны бүртгэлийн ангилал:	I ангилал	I ангилал
Зарласан хувьцааны тоо:	25,000,000 ширхэг	25,000,000 ширхэг
Эргэлтэд гаргасан хувьцааны тоо:	5,000,000 ширхэг	17,500,000 ширхэг
Халаасалсан хувьцааны тоо:	1,243,016 ширхэг	0 ширхэг
Олон нийтэд санал болгох хувьцааны тоо:	1,560,754 ширхэг	7,500,000 ширхэг
Олон нийтэд санал болгох хувь:	25.00%	30.00%
Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ:	1,000 төгрөг	200 төгрөг
Санал болгож буй хувьцааны нэгж үнэ:	4,800 төгрөг	700 төгрөг
Нэгж хувьцааны дансны үнэ:	1,200 төгрөг	299 төгрөг
Нэгж хувьцааны бизнесийн үнэлгээ:	4,723.83-5,041.72 төгрөг	1,164 төгрөг
Хямдруулсан хувь:	4.8% (5,041.72 төгрөгөөс тооцсон)	39.9%
Нийт татан төвлөрүүлэх хөрөнгийн үнийн дүн:	7,491,619,200 төгрөг	5,250,000,000 төгрөг
Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт:	Хувь нийлүүлсэн хөрөнгө/мөнгөн хөрөнгийг нэмэгдүүлэх	Дүрмийн сан болон өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх
Анхдагч зах зээлийн захиалга авах хугацаа:	2018.09.04 - 2018.09.18	2018.09.17 - 2018.09.26
Анхдагч захиалгын хуваарилалт:	Суурь хуваарилалт хийх мөнгөн дүнг 1 тэрбум төгрөгөөр тооцон нийт захиалга өгсөн хүний тоонд тэнцүү хуваарилна. Үлдэгдэл 6.49 тэрбум төгрөгийг нийт захиалгын мөнгөн дүнтэй харьцуулан хувь тэнцүүлэн хуваарилна.	Хуваарилалтын зарчмыг МХБ-тэй зөвшилцөн шийдвэрлэнэ
Ногдол ашгийн бодлого:	Ойрын жилүүдэд ногдол ашиг хуваарилахгүй	Цэвэр ашгийн 30-50%
Компани, 2017 он		
Байгуулагдсан огноо:	2011 он	1994 он
Хувьцаа эзэмшигчдийн тоо:	1. “Голомт файнэншил групп” ХХК - 51%; 2. “Юу Эм Си капитал” ХХК - 49%	1. “Ард санхүүгийн нэгдэл” ХК - 95.31%; 2. “Энержи интернэйшнл капитал” ХХК - 4.69%
Салбар, нэгжийн тоо:	280 банкны салбар	24 салбар, 238 төлөөлөгч
Даатгуулагчдын тоо:	45,997	26,979
Зах зээлд эзлэх хувь:	16%	11%
Нийт хөрөнгө:	21,472 сая төгрөг	11,727 сая төгрөг
Нийт хураамжийн орлого:	22,533 сая төгрөг	10,355 сая төгрөг
Давхар даатгалд шилжүүлсэн хураамжийн хувь:	50%	32%
Цэвэр хураамжийн орлого:	10,081 сая төгрөг	6,912 сая төгрөг
Цэвэр ашиг:	1,103 сая төгрөг	1,124 сая төгрөг
Цэвэр ашгийн маржин:	4.90%	10.85%
Цаашдын зорилт:	1. Зах зээлд эзлэх байр суурийг өсгөх; 2. Давхар даатгалын хураамжийг бууруулах; 3. Хөрөнгө оруулалтын хэмжээг өсгөх; 4. Жижиг даатгалын компаниудыг нэгтгэх	1. Зах зээлд эзлэх байр суурийг өсгөх; 2. Хөрөнгө оруулалтын хэмжээг өсгөх; 3. “Монгол шуудан” ХК-ийн салбараар дамжуулан даатгалын үйлчилгээг үзүүлэх

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

УУХҮЯ: АИ-92-ын хилийн үнэ нэмэгдсэн

9-р сард ОХУ-аас импортолж байгаа газрын тосны бүтээгдэхүүний хилийн үнэ 8-10 ам.доллараар нэмэгдсэн талаар Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яам мэдээллээ. Ингэснээр нэг тонн АИ-92 авто бензиний хилийн үнэ 721 ам.доллар, дизель түлшний хилийн үнэ 673 ам.доллар болсон байна.

Импортолж байгаа шатахууны хилийн үнэ 40 орчим хувиар өссөнөөс хамаарч дотоодод шатахууны үнэ өнгөрсөн оны мөн үеэс 250 орчим төгрөгөөр нэмэгдсэн талаар Төв банк өмнө нь мэдээлж байсан юм. Хэдий тийм боловч цаашид Засгийн газар татварын зохицуулалт хийхээр импортлогч компаниудтай ярилцаж, Олон Улсын Валютын Сантай зөвшилцсөний дараа Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэнэ гэж Уул уурхай, Хүнд үйлдвэрийн сайд мэдэгдээд байна.

Наймдугаар сарын 28-ны өдрийн байдлаар ердийн хэрэглээний 38 хоногийн газрын тосны бүтээгдэхүүний нөөцтэй байна. Харин экспортын тухайд наймдугаар сарын 15-ны байдлаар 569 мянган тонн газрын тос олборлож, 558 мянган тонныг экспортолсон талаар Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яам мэдээллээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

“Discover Mongolia 2018” юуг онцлов

“Discover Mongolia” чуулганы хоёр дахь өдөр татварын орчны гаднын хөрөнгө оруулагчдад илүү таатай болгож, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх хэрэгтэй байгааг судлаачид онцоллоо. Тухайлбал, одоогоор 2.5 хувьтай байгаа алтны роялтиг хэвээр үргэлжлүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Харин чуулганы эхний өдөр уул уурхайн хайгуул, олборлолт, болоод нэмүү өртөг шингэсэн боловсруулах салбарын үйлдвэрлэл, түүнчлэн дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэхэд 2030 он хүртэл 20 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай байгааг Уул уурхай, Хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар мэдээлж байсан юм. Мөн тэрбээр хайгуулын тусгай зөвшөөрлийг зөвхөн сонгон шалгаруулалтаар бус өргөдлөөр олгох эрх зүйн зохицуулалт хийхээр судалж байгаагаа илэрхийллээ.

Чуулганы үеэр “Aspire Mining” компанийн Үйл ажиллагаа хариуцсан захирал Дэвид Полл “Монголын коксжих нүүрсний экспортын 20-30 хувийг хангах нөөцтэй ордилруулээд байгаа”-гаа мэдээлэв. Мөн “Хармагтай” ордыг ашиглахад зардал бага гарах нь тогтоогдсон гэж “Xanadu Mines” компанийн Гүйцэтгэх захирал зарласан юм. Үүнээс гадна “Эрдэнэс Монгол” компани газрын тос, газрын ховор элементийн чиглэлээр компани байгуулж, компанийн давуу эрхийн хувьцааг таван сая болгон дүрэмд тусгахаар ажиллаж байгаа талаар мэдээллээ.

Мөн “Erdene Resource Development” компани 2020-21 онд 1.5 сая унци алтны нөөц бүхий орд газарт олборлолт хийхээр төлөвлөж ажиллаж байгаа. Жилийн алтны гарц 60-70 мянган унци байх урьдчилсан тооцоо гарчээ.

Түүнчлэн, “Оюу толгой” ХХК-ийн ТУЗ эрчим хүч, цахилгаантай холбоотой судалгааг бүрэн гүйцэд дуусгах, шийдэл гаргах чиглэлээр төсөв хөрөнгөө баталсан. Хөрөнгө оруулагч “Рио Тинто” компани болон Эрчим хүчний яам хооронд яриа хэлэлцээ үргэлжилж байгаа гэдгийг “Оюу Толгой” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Армандо Торрес мэдэгдсэн юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

Монгол улс боловсруулсан алтаа 100 хувь Их Британид гаргаж байна

Энэ оны эхний 7 сарын байдлаар манай улс экспортод 4.116.7 сая ам.долларын бараа, түүхий эд гаргаж, 3.265.7 сая ам.долларын бараа, түүхий эд импортоор авчээ.

УУХҮЯ-ны мэдээллээр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад экспорт 596.4 сая ам.доллараар буюу 16.9 хувиар, импорт 929.0 сая ам.доллараар буюу 39.8 хувиар өсөөд байна. Экспорт, импортын зөрүү 851.0 сая ам.долларын эерэг үзүүлэлттэй гарчээ. Экспортод боловсруулаагүй нефть, төмрийн хүдэр болон цайрын баяжмалыг 100 хувь, зэсийн баяжмалын 99.8 хувийг БНХАУ-д, жоншны 53.7 хувийн мөн урд хөршид, 46.0 хувийг ОХУ-д, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алтыг 100 хувь Их Британид тус тус гаргасан байна. Манай улс дэлхийн 60 оронд бараа экспортлосноос БНХАУ-д 92.3 хувь, Их Британид 3.8 хувь, ОХУ-д 1.2 хувь тус тус ногдож, нийт экспортын 97.3 хувийг дээрх орнууд эзэлж байна.

Харин импортоор нийлүүлсэн барааны нийт дүнд машин механизм, тоног төхөөрөмж болон эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг 683.6 сая ам.доллар буюу 20.9 хувь, эрдэс бүтээгдэхүүн 730.4 сая ам.доллар буюу 22.4 хувийг эзэлж байна. Үүний дотор нефтийн бүтээгдэхүүн 604.0 сая ам.доллар буюу 82.7 хувь, үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн 318.9 сая ам.доллар буюу 9.8 хувийг, химийн болон үйлдвэрийн бүтээгдэхүүн 205.1 сая ам.доллар буюу 6.3 хувийг тус тус эзэлж байна. Нийтдээ гадаад худалдааны бараа эргэлт 7.382.3 сая ам.долларт хүрснийг өнгөрсөн оны үетэй харьцуулвал 1.525.3 сая ам.доллараар буюу 26.0 хувиар өссөн дүнтэй гарчээ.

Эх сурвалж: Montsame.mn

CRU: 2020 он гэхэд дэлхийн коксжих нүүрсний хэрэглээ 1.13 тэрбум тоннд хүрч өсөхөөр байна

Улаанбаатар хотод түүхий нүүрс оруулахыг хориглосон шийдвэртэй холбоотойгоор шахмал түлш үйлдвэрлэгчид консорциум буюу “нэгдэл” байгуулжээ.

Консорциумд багтсан 12 компани энэ жилдээ 80 мянган тонн шахмал түлш үйлдвэрлэхээр болсон байна. Нийслэлийн гэр хорооллын оршин суугчид жилд 1.1 сая тонн шахмал түлш хэрэглэдэг гэж Нийслэлийн Засаг даргын тамгын газраас мэдээллээ. Харин түүхий нүүрсийг шахмал түлшээр солиход жилд 600-800 мянган тонн шахмал түлш шаардлагатай аж.

Шахмал түлш үйлдвэрлэгч 12 компанийн гарц, үйлдвэрлэлийн хүчин чадлыг бодлогоор дэмжиж нэмэгдүүлэх боломжтойг “Монголын шахмал түлш үйлдвэрлэгчдийн нэгдэл” онцоллоо. Мөн тонн тутамд нь Засгийн газраас 50 мянган төгрөгийн татаас өгөхөөр болсон нь шахмал түлшний хэрэглэгчдэд хүрэх үнийг 150 мянган төгрөг буюу түүхий нүүрсний үнээс ихгүй байх боломжийг бүрдүүлсэн гэж түлш үйлдвэрлэгчид онцолж байна. Улаанбаатар хотын гэр хорооллын иргэд түлшний хэрэглээний 20 орчим хувийг хэрэглэдэг ч агаарын бохирдлын 80 хувийг бий болгож байгаа ажээ. Харин 10 хувийг тээврийн хэрэгсэл, зургаан хувийг Дулааны цахилгаан станцын утаа эзэлж байна.

Шахмал түлш нь агаарын бохирдлыг бууруулах ойрын хугацааны шийдэл бөгөөд харин цаашид гэр хорооллын иргэдийг дулааны алдагдалгүй байшин, орон сууцны санхүүжилтийн шийдлийг эрэлхийлэх хэрэгтэй болохыг “Coal Mongolia” чуулганд оролцогчид онцоллоо.

Эх сурвалж: BloombergTv.mn

БУСАД МЭДЭЭ

Өрсөлдөх чадварын индексээр Монгол улс 101 дүгээрт жагсчээ

Дэлхийн эдийн засгийн форумаас гаргасан өрсөлдөх чадварын индексээр Монгол Улс дэлхийн 137 орноос 101 дүгээрт жагссан байна.

Энэ удаад Швейцарь, АНУ, Герман, Сингапур, Нидерланд, Хонгконг зэрэг улс өрсөлдөх чадварын индексээрээ тэргүүлсэн бол ОХУ 38-т, Хятад улс 27 дугаар байрт эрэмблэгджээ.

Дэлхийн эдийн засгийн форум өрсөлдөх чадварын индексийг тогтооходоо 12 тулгуур үзүүлэлт болон 115 дэд үзүүлэлтийг шалгуур болгодог бөгөөд манай улс 3.9 оноо авч өнгөрсөн жилээс нэг байраар урагшилжээ.

115 дэд үзүүлэлтээс манай улс 10 гаруйд нь эхний 50-т жагссан байна. Тодруулбал, цалин хөлс тогтоох уян хатан байдал, татварын нийт хувь, ажлаас халахад гарах зардлын хэмжээ, хөрөнгө оруулагчдын хамгаалалт зэргээр 12-28 дугаар байрт багтсан байна.

Энэ жилийн хувьд манай улс макро эдийн засгийн тогтвортой байдал 0.8, дэд бүтэц 0.2 оноогоор дээшилсэн бол эрүүл мэнд, дээд боловсрол, мэргэжлийн сургалтын чанар, санхүүгийн зах зээлийн хөгжил зэрэг 6 тулгуур үзүүлэлтийн оноо 0.1 нэгжээр буурчээ.

Эх сурвалж: Montsame.mn

Монголбанк VIII сард 2.8 тонн алт худалдан авчээ

2018 оны наймдугаар сард Төв банк 2.8 тонн алт худалдан авсан байна. Ингэснээр Монголбанкны худалдаж авсан алт оны эхний найман сарын байдлаар 12.2 тонн хүрч өмнөх оны мөн үетэй ижил түвшинд хүрээд байна. Оны эцэст худалдан авсан алтны хэмжээгээ өмнөх оныхоос 10 хувиар нэмэгдүүлж, 22 тоннд хүргэх зорилт тавиад байгаа юм. Алтны нөөц ашигласны татварыг “Алт” хөтөлбөрийн хүрээнд 2.5 хувь болгож хөнгөлсөн ч хугацаа нь 2019 онд дуусах юм. Энэхүү хөнгөлөлтийг 2019 оноос цааш сунгах шаардлагатай байгааг Төв банк онцолж байна. Ингэснээр алт тушаалтын хэмжээ өндөр түвшинд хадгалагдаж гадаад валютын албан нөөц нэмэгдэх боломжтой гэж мэдээллээ. Алтны татвар өндөр үед Төв банканд тушаасан алтны хэмжээ 2010 онд хоёр тонн хүртлээ буурч байсан байна. Харин татварын хэмжээ буурснаар алт тушаалт тогтвортой өсөж, өнгөрсөн онд түүхэн дээд түвшинд хүрсэн юм.

Алт үйлдвэрлэгчид Ажахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд гурван тэрбум төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой бол 25 хувийн татвар авдаг нь татварын дарамт нэмдэг аж. Мөн зарим тохиолдолд лицензийг хүчингүй болгосноор алт олборлолтын үйл ажиллагаа удааширдаг байна. Холбогдох газруудын зүгээс олон удаа шаардлагагүй хяналт шалгалт хийдэг зэрэг хүндрэлүүдийг Төв банкны удирдлагуудад уламжилж байсан юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

Монгол, БНСУ-ын худалдааны эргэлт 200 сая ам.долларт хүрчээ

1990 онд ердөө 2.7 сая ам.доллараар хэмжигдэж байсан Монгол, БНСУ-ын хоёр талын худалдааны эргэлт 2017 онд 200 сая ам.долларт хүрч нэмэгдсэн байна.

Энэ талаар МҮХАҮТ-ын Ерөнхийлөгч Б.Лхагважав БНСУ-ын Тэгү хотын ХАҮТ-ын төлөөлөгчдийг хүлээн авч уулзах үеэр мэдэгдлээ. Б.Лхагважав МҮХАҮТ-ын үйл ажиллагааны талаар болон Монгол Улсын эдийн засаг, бизнесийн орчны талаар төлөөлөгчдөд танилцуулах үеэр, Монгол, Япон улсын хооронд байгуулаад 2 жил болж буй Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр амжилттай хэрэгжиж байгааг дурдаад, Монгол Улс, Өмнөд Солонгосын чөлөөт худалдааны хэлэлцээрт МҮХАҮТ голлох үүрэгтэй ажиллаж байна гэв.

Тэрээр, “Монгол Улс болон БНСУ нь хоёр талын Эдийн засгийн түншлэлийн гэрээ байгуулах асуудлаар 2016 оноос хийж эхэлсэн хэлэлцээр нь чөлөөт худалдааны хэлэлцээртэй адил төстэй бөгөөд үүнийг байгуулснаар аж үйлдвэр болон хөрөнгө оруулалтын салбарын хамтын ажиллагаа улам бүр бэхжих боломжтой юм. Өнөөдрийн байдлаар хоёр орны чөлөөт худалдааны хэлэлцээр судалгааны түвшинд байгаа юм. 1990 онд ердөө 2.7 сая ам.доллараар хэмжигдэж байсан хоёр талын худалдааны эргэлт 2017 онд 200 сая ам.долларт хүрч нэмэгдээд байна” гэв. БНСУ-ын Тэгү хотын ХАҮТ-ын бизнесийг дэмжих газрын захирал До Сүн Ук Танхимынхаа талаар танилцуулж, тус хотын төлөөлөгчид Монголын аж ахуйн нэгж, компаниудтай хамтран ажиллах, харилцаа холбоогоо сайжруулахад МҮХАҮТ-ын зүгээс анхаарч, дэмжиж ажиллахыг хүслээ. БНСУ-ын Тэгү хотын ХАҮТ нь 1906 онд байгуулагдсан 100-н жилийн түүхтэй байгууллага юм байна.

Эх сурвалж: Montsame.mn

Иргэдэд олгосон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 2.2 нэгж хувиар буурчээ

Иргэдэд олгосон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү оны эхнээс 2.2 нэгж хувиар буурч, долоодугаар сарын эцэст 18.1 хувь болсон байна. Харин бизнесүүдэд олгосон зээлийн хүү 17.5 хувьд хүрсэн нь оны эхнээс 0.5 нэгж хувиар буурсан үзүүлэлт боллоо. Зээлийн эх үүсвэр болох хадгаламжийн жигнэсэн дундаж хүү тайлант сард 11.2 хувь болсон нь оны эхнээс 1.8 нэгж хувиар буурсан үзүүлэлт болжээ. Хувийн байгууллагуудаас татсан хадгаламжийн хүүний түвшин үүнээс бага буюу 8.5 хувь байна. Төв банк бодлогын хүүгээ оны эхний улиралд 10 хувьд хүргэж буулгасан нь сүүлийн есөн жилийн хамгийн доод түвшин болсон юм. Мөнгөний зөөлөн бодлого хадгаламжийн хүү буурч, улмаар зээлийн хүү буурч байгааг Төв банк онцолж байна.

Монгол Улсад зээлийн хүү дундаас доогуур орлоготой орнуудын дундажтай харьцуулахад таван нэгж хувиар, Зүүн Ази, Номхон далайн орнуудын дундажтай харьцуулахад 10 гаруй нэгж хувиар өндөр байгаа юм. Тиймээс Төв банк зээлийн хүү бууруулах стратеги боловсруулж УИХ-д танилцуулаад байна. Энэ хүрээнд макро эдийн засгийн тогтвортой орчин бүрдүүлэх, мөнгөний бодлогоор нөлөөлөх, банкнуудын үр ашигт удирдлагыг нэвтрүүлэхийг зорьж байгаа юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.